

ГАЗРЫН ХАРИЛЦААНЫ ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨХӨӨРӨМЖ “КИОСК”-ИЙН ТУХАЙ

Газрын харилцааг боловсронгуй болгох, цахимжуулах, газрын харилцааны үйлчилгээг иргэдэд ойртуулах, хүнд суртлыг арилгах ажлын хүрээнд газрын харилцааны цахим үйлчилгээний Киоск машиныг 2022 оноос нэвтрүүлж эхэлсэн бөгөөд өнөөгийн байдлаар улсын хэмжээнд 2022-2023 онд нийт 50, 2024 онд нийт 39 Киоск машиныг суурилуулж, хэрэглээнд нэвтрүүлээд байна.



Киоск машиныг хэрэглээнд нэвтрүүлснээр иргэн, хуулийн этгээд нь газрын харилцааны чиглэлээр нийт 16 төрлийн үйлчилгээ, мэдээллийг нэг дороос 1 минутын дотор авах боломжтой болсон байна.

Мөн Киоск машиныг ашиглан 52 төрлийн өргөдлийг цахимаар өгөх, 12 төрлийн мэдээлэл, лавлагаа, тодорхойлолтыг хэвлэн авах, мөн цахим хүсэлт өгөх, өргөдлийнхөө явцыг шалгах, цахим гэрээ, гэрчилгээ үүсгэх, газрын төлбөр шалгах, газрын төлбөрөө QR-аар төлөх үйлчилгээнүүдийг авах боломжтой юм.


 1500₮ Үнэгүй газар өмчилсөн эсэх лавлагаа	 1500₮ Хамтран өмчилсөн эсэх лавлагаа	 3000₮ Нэгж талбарын тодорхойлолт	 0₮ Эд хөрөнгийн эрхийн мэдүүлэг	 1000₮ Барьцааны тодорхойлолт	 2500₮ Кадастрын зураг хэвлэх
 2000₮ Гэрчилгээ хэвлэх	 1000₮ Гэрээ хэвлэх	 1500₮ Тооцоо нийлсэн акт	 0₮ Хянан баталгааны мэдэгдэх хуудас авах	 1000₮ Хянан баталгааны дүгнэлт хэвлэх	
 Үнэгүй Цахим хүсэлт гаргах	 Үнэгүй Хүсэлт шалгах	 Үнэгүй Өргөдөл шалгах	 Үнэгүй Төлбөрийн мэдээлэл харах	 Үнэгүй Гэрээ үүсгэх	 Үнэгүй Гэрчилгээ үүсгэх

Газрын харилцааны цахим үйлчилгээний Киоск машиныг суурилуулж байршуулсан байдлыг аймаг, нийслэлээр дараах хүснэгт болон зургаар харуулав.

Суурилуулсан киоск машины тоо (аймаг, нийслэлээр)


ДД	Аймгийн нэр	Киоскийн тоо	ДД	Аймгийн нэр	Киоскийн тоо
1	Архангай	5	12	Өвөрхангай	5
2	Баян-Өлгий	1	13	Өмнөговь	18
3	Баянхонгор	1	14	Орхон	2
4	Булган	0	15	Сүхбаатар	1
5	Говь-Алтай	1	16	Сэлэнгэ	0
6	Говьсүмбэр	1	17	Төв	12
7	Дархан-Уул	0	18	Увс	1
8	Дорноговь	1	19	Ховд	1
9	Дорнод	0	20	Хөвсгөл	3
10	Дундговь	5	21	Хэнтий	2
11	Завхан	1	22	Нийслэл	29
НИЙТ		89			

Хэрэглээнд нэвтрүүлсэн Киоскийн тоо




КИОСК МАШИНААС ҮЙЛЧИЛГЭЭ АВАХ ЗААВАР


1. Үйлчилгээ авах гэж буй иргэн, хуулийн этгээд нь Киоск машин дээрх “Газрын үйлчилгээ авах” товчийг дарснаар нэвтрэх цонх нээгдэнэ.



2. Иргэн, хуулийн этгээд нь регистрийн дугаар болон Газрын албанд бүртгэлтэй утасны дугаараар өөрийн газрын мэдээлэлд нэвтэрнэ.



3. Нэвтэрсний дараа тухайн үйлчлүүлэгчийн утасны дугаарт мессеж очно. Системд нэвтэрсний дараа үйлчлүүлэгч газрын харилцааны үйлчилгээний цонхноос сонголтоо хийнэ.



4. Авах гэж буй үйлчилгээгээ сонгосноор тухайн хэрэглэгчийн бүртгэлтэй газрын жагсаалт гарах ба үйлчилгээ авах газраа сонгосноор хэвлэх цонх нээгдэнэ.

НЭГЖ ТАЛБАРАА СОНГОНО УУ


НЭГЖ ТАЛБАРЫН ДУГААР: 123305716
ЭРХИЙН ТӨРӨЛ: 339МЦИХ
БАЙРШИЛ: УЛААНБААТАР, БАЯНЗҮРХ
ӨРГӨДЛИЙН ДУГААР: 01110-05-0302-23
ӨРГӨДЛИЙН ЯВЦ: 9: ГЭРЭЭ БАЙГУУЛЖ ГЭРЧИЛГЭЭ ОЛГОХ / ӨМЧЛӨЛИЙН БҮРТГЭЛ
ӨРГӨДЛИЙН ТӨРӨЛ: 5: ШИНЭЭР ГАЗАР 339МЦИХ


НЭГЖ ТАЛБАРЫН ДУГААР: 133305717
ЭРХИЙН ТӨРӨЛ: 339МЦИХ
БАЙРШИЛ: УЛААНБААТАР, БАЯНЗҮРХ
ӨРГӨДЛИЙН ДУГААР: 01110-05-0302-23
ӨРГӨДЛИЙН ЯВЦ: 9: ГЭРЭЭ БАЙГУУЛЖ ГЭРЧИЛГЭЭ ОЛГОХ / ӨМЧЛӨЛИЙН БҮРТГЭЛ
ӨРГӨДЛИЙН ТӨРӨЛ: 5: ШИНЭЭР ГАЗАР 339МЦИХ

НЭГЖ ТАЛБАРЫН ДУГААР: 178118228
ЭРХИЙН ТӨРӨЛ: 339МЦИХ
БАЙРШИЛ: УЛААНБААТАР, ХАН УУЛ
ӨРГӨДЛИЙН ДУГААР: 01122-05-0257-23
ӨРГӨДЛИЙН ЯВЦ: 9: ГЭРЭЭ БАЙГУУЛЖ ГЭРЧИЛГЭЭ ОЛГОХ / ӨМЧЛӨЛИЙН БҮРТГЭЛ

БҮЦЭХ

5. “Print” товчийг дарснаар авах мэдээллээ хэвлэх ба хэвлэсэн лавлагааг Киоск машинаас авна.





6. Үйлчилгээг авсны дараа дахиад үйлчилгээ авах бол “ӨӨР ҮЙЛЧИЛГЭЭ АВАХ” үгүй бол “ГАРАХ” товчийг дарснаар системээс гарна.

КИОСК МАШИНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНЭ ТАРИФ

Архивын ерөнхий газрын даргын 2023 оны А/68 дугаар тушаалаар газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн баримтын архиваас үзүүлэх үйлчилгээний хөлсний хэмжээ, түүний дотор газрын харилцааны цахим системээс мэдээ, мэдээллээр үйлчлэх үнэ, тарифыг тогтоосны дагуу Киоск машинаас үйлчилгээг авахад дараах үнэ, тарифыг мөрдөж байна.

Киоск машины үйлчилгээний үнэ тариф

9. Газрын удирдлагын нэгдсэн цахим системээс архивын мэдээллээр үйлчлэх:

Д/д	Үйлчилгээний төрөл	Төлбөрийн хэмжээ (төгрөг)
1	2	3
1	Нэгж талбарын тодорхойлолт	3 000
2	Газар өмчлөх, эзэмших эрхийг барьцаалсан эсэх лавлагаа	1 500
3	Газрын эрх шүүхийн шийдвэртэй эсэх лавлагаа	1 500
4	Газар өмчлөх, эзэмших, ашиглах эрх олгосон шийдвэрийн хуулбар	1 000
5	Монгол улсын иргэнд төрөөс нэг удаа үнэ төлбөргүй газар өмчлүүлсэн эсэх лавлагаа	1 500
6	Монгол улсын иргэнд төрөөс нэг удаа үнэ төлбөргүй газар хамтран өмчлүүлсэн эсэх лавлагаа	1 500
7	Газрын төлбөрийн дэлгэрэнгүй лавлагаа	1 500
8	Газрын төлбөрийн тооцоо нийлсэн акт	1 500
9	Нэгж талбарын кадастрын зураг (баталгаажсан)	2 500
10	Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ	2 000
11	Газар эзэмшүүлэх, ашиглуулах гэрээ	1 000
12	Газрын дуудлага худалдааны анхны үнийн лавлагаа	1 500
13	Нэгж талбарын газрын суурь үнэлгээний мэдээлэл лавлагаа	1 500

